

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 1 дүүгэр
сарын 29-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

“Монгол траст холдинг даатгал” ХХК-ийн
даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, Даатгалын тухай хуулийн 67.1.2, 69.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Монгол траст холдинг даатгал” ХХК-ийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 1 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд даатгалын нөөцийн сангийн хөрөнгийг өөрийн компанийн дансанд оруулан холбогдох журмын дагуу байршуулаагүй, өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авах болохыг “Монгол траст холдинг даатгал” ХХК-д анхааруулсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ